

Үзүүлэлтүүд:




<p><b>ДНБ -1.7%</b> 2016 оны III-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр</p> <p>Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.</p>	<p>ГШХО 11-р сард <b>-18.6 сая ам.доллар</b></p> <p>Цэвэр ГШХО 11-р сарын байдлаар -18.6 сая ам.доллар болж өмнөх сараас өссөн үзүүлэлттэй гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86.4 сая ам.доллараар буув.</p>	<p>Төсвийн алдагдал <b>-3667 тэрбум төгрөг</b></p> <p>Төсвийн орлого 5852 тэрбум төгрөг, зарлага 9519 тэрбум төгрөг болж тэнцрэл (3667) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Инфляци <b>1.1%</b></p> <p>Өмнөх сараас 0.7 хувиар, оны эхнээс 1.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 1.1 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээл <b>1052 тэрбум төгрөг</b></p> <p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 7.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувиар нэмэгдэж 1052 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.4% байна.</p>	<p>Валютын нөөц <b>1 тэрбум ам.доллар</b></p> <p>Монголбанкны валютын нөөц 11-р сард өмнөх оны мөн үеэс 10.6 хувь буюу 155 сая ам.доллараар буурч 1304 сая ам.доллар болов.</p>
--	--	---	---	---	---

<p><b>\$</b></p> <p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш <b>2482.57 ₮</b></p>	<p><b>1.009</b></p> <p>Орон сууцны үнийн индекс Өмнөх сараас 0.1%-иар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 4.3%-иар буув.</p>	<p><b>14%</b></p> <p>Монголбанкны бодлогын хүү</p>
---	---	--

Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулан 14 хувь болгов. Монголбанкнаас валютын ханшийн тогтворгүй байдал гүнзгийрэхээс сэргийлэн өнгөрсөн 8 дугаар сард мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлсэн. Энэ алхамаа тэд гадаад валютын нөөцийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад үр дүнгээ өгсөн хэмээн тодотгов.

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2014 он		2015 он		2016 оны 12-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	19.5	0.8	14.4	0.6	25.7	9.7
Төмрийн хүдэр	6.3	0.4	6.3	0.2	6.1	2.4
Зэсийн баяжмал	1.4	2.5	1.4	2.3	1.5	1.6
<b>Нийт</b>	<b>27</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>33</b>	<b>14</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2017 оны нэгдсэн төсөвт 117 төсөл, арга хэмжээг 857 тэрбум гаруй төгрөгийн гадаад зээл, тусламжаас санхүүжүүлэхээр тусгажээ.


**ДНБ**

ДНБ 2016 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 193.3 тэрбум төгрөгөөр буурч эдийн засгийн өсөлт 1.7 хувиар буурав. ДНБ-ий 1.7 хувиар буурахад аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар буурч зарлага 33.4 хувь өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 3667 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оноос 2510.9 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 35.6 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.




**Валютын ханш**

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 486 төгрөг буюу 24.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 48.2 төгрөг буюу 2.0 хувиар өсч 2482.57 төгрөгт хүрэв.



**Инфляци**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 12-р сард өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсч, өмнөх оны эцсээс 1.1 хувиар өсөв. 2016 оны 12 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 28.3 хувийнх нь үнэ өсч, 11.8 хувийнх нь буурч, 59.9 хувийнх нь үнэ тогтвортой байжээ.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УЦХ, Монголбанк

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 11-р сарын байдлаар 1304 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 25.5 хувь буюу 265 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 10.6 хувь буюу 155 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**

2016 оны арванхоёрдугаар сард 150.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 38.3 сая үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 3.3 хувиар буурсан бол арилжсан үнэт цаас 11.8 дахин өсөв. ТОП-20 дундаж индекс 2016 оны арванхоёрдугаар сард 11605 нэгж болж, өмнөх сарынхаас 755, өмнөх оны мөн үеийнхээс 673 нэгжээр буурчээ.



\*Монголын хөрөнгийн бирж

**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар, өнгөрсөн сараас 3.9 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 16.5 хувиар, өмнөх сараас 7.1 хувиар нэмэгдэж нийт мөнгөний 6.8 хувийг эзэлж байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2016 оны 12-р сард 8.5 их наяд төгрөг болж өмнөх сараас 280 тэрбум төгрөг буюу 3.4 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 15.8 хувиар буюу 1165.4 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 4 хувиар буюу 107.8 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 6.1 хувиар буюу 172.2 төгрөгөөр өсөв.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 12-р сард өмнөх сарынхаас 2.3 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1052 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 7.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.5% байна.



**Ипотекийн зээл**


2016 оны 12-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1 хувь (38.8 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.1 хувь (585.3 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4 их наяд төгрөгт хүрэв. Арванхоёрдугаар сард нийт 601 зээлдэгчид 38.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 89156-д хүрэв. 2016 оны арванхоёрдугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.3 хувь нь төгрөгийн зээл, 0.7 хувь нь валютын зээл байна.



## Гадаад худалдаа

## Гадаад худалдаа

2016 оны арванхоёрдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 8275 сая ам.доллар, үүнээс экспорт 4917 сая ам.доллар, импорт 3357 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 1559 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2.2 хувиар буурч, экспортын хэмжээ 5.3 хувиар өссөн бол импортын хэмжээ 11.5 хувиар буурсан байна. Экспорт 2016 онд өмнөх оноос 248.1 (5.3%) сая ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 194.3 сая ам.доллар, үүнээс зэсийн баяжмал 672.5 сая ам.доллар, боловсруулаагүй нефть 50 сая ам.доллар буурсан ч үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт 340.1 сая ам.доллар, нүүрсний экспорт 417.1 сая ам.доллар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



\* Эх сурвалж УЦХ, Монголбанк

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оны 11-р сард -18.6 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 86.4 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.4 сая ам.доллар байсан бол Монгол Улсад -11.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



\* Эх сурвалж Монголбанк

## Монгол Улсын гадаад өр

### Гадаад өр

2016 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4.7 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 23.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 1 хувь (53 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1 хувь (335 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 10 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



\* Эх сурвалж Монголбанк

## Сарын онцлох үйл явдал

### 12.14

Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг санхүүжүүлэхээр болов. Үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалт 1 тэрбум ам.доллар бөгөөд боловсруулах үйлдвэр 0.7 тэрбум гаруй ам.доллар, газрын тос дамжуулах хоолой 264 сая ам.доллар, жилд 1.2 тэрбум ам.долларын борлуулалт хийн, жилийн 43 сая ам.долларын цэвэр ашигтай, хөрөнгө оруулалтаа 8-10 жилийн дотор нөхнө гэж тооцож байна. Үйлдвэр жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулж, евро-4,5 стандартын шаардлага хангасан 560 мянган тонн автобензин, 670 мянган тонн дизель түлш, 107 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий, бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм.

### 12.28

Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаас “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. Хөтөлбөрт туссан 6 зорилго, 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан байна. Энэ хүрээнд ирэх оны эхний хагаст 60, жилийн турш 80, 2018 оны эхний хагас жилд 84 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ